



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/106

Есөнбулаг сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 15 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.1 дэх зорилт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлгэр сумын Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн түүхт 60-н жилийн ойг тохиолдуулан сургалтын тоног төхөөрөмж худалдан авах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 15,000,000 (Арван таван сая) төгрөгийг боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

